

Рупа Дуттагупта: Европын хямрал хурцадвал түүхий эдийн үнэ 25 хувиар унах эрсдэлтэй

ОУВС-гийн Судалгааны газрын хэлтсийн орлогч дарга Рупа Дуттагупта өнгөрсөн баасан гарагт манай улсад ирж хэлтсээсээ гаргадаг “Дэлхийн эдийн засгийн тойм”-ын талаар илтгэл тавьсан юм. Илтгэлийнх нь дараа түүнтэй ярилцлаа.

- **Европын эдийн засгийн хямрал дэлхийг хамарч магадгүй гэсэн болгоомжлол өнөөдрийг хүртэл хүчтэй хэвээр байна. Европын холбооны улсуудын хэрэгжүүлж байгаа бодлого үр дүнгээ үзүүлэхгүй бол яах вэ?**
- Дэлхийн эдийн засгийн хамгийн том эрсдэл бол яах аргагүй Европын бүсэд явагдаж буй хямрал. Нэг хэсэг дэвэрч байгаад намжсан. Буцаад хямарвал яах вэ гэдэг асуудал бий. Европын улсуудын Засгийн газраас тодорхой арга хэмжээ аваад эхэлчихсэн. Тэр арга хэмжээнд нь зах зээлийн оролцогчид идэвхигүй байвал яах вэ гэдэг асуудал гарч ирнэ л дээ. Төлөвлөсөн арга хэмжээгээ зохих ёсоор хэрэгжүүлээд хүлээсэн үр дүндээ хүрч чадахгүй бол яах вэ гэдэг эрсдэл ч бий. Хэрвээ тийм байдал үүсвэл зах зээлд оролцогчид Засгийн газраас илүү шийдвэртэй арга хэмжээ авахыг шаардаж эхэлнэ. Европын бүсийн Засгийн газрын өрийн бичгийн хүүгийн төвшин ч цаашдаа өсч магадгүй. Хэрвээ байдал муудвал хүүгийн түвшин өндөрсөөд ирнэ. Тэгэхээр Засгийн газрууд эх үүсвэр татахад өртөгтэй болж ирнэ гэсэн үг. Тэр нь цаашлаад банкуудад ч нөлөөлнө. Банкууд Засгийн газрын өрийн бичгүүдийг их хэмжээгээр худалдаад авчихсан байдаг учраас тодорхой хэмжээний дарамтад орно. Ер нь Засгийн газар, банк, нийт эдийн засаг гурав салшгүй холбоотой. Засгийн газрын байдал муудвал банкуудад, банкууд нь муудвал эдийн засгийнхаа өсөлтөд нөлөөлдөг. Эдийн засаг нь муудаад ирвэл Засгийн газар нь нэмэлт арга хэмжээ авах ёстой гээд гинжин урвал маягаар явагддаг зүйл л дээ. Ийм гинжин урвал явагдах холбоосууд үүсчихсэн учраас нөхцөл байдал муудвал дэлхийн эдийн засгийн өсөлт 3,5 хувиар нэмж буурах эрсдэл үүсчихээд байна.
- **Грекийн асуудал бүрэн шийдэгдэж чадсан уу, энэ улс шиг том асуудал авчрах эрсдэлтэй ямар улс байна?**
- Одоогоор Грек шиг тийм том асуудалтай тулгарсан улс байхгүй гэж үзэж байгаа. Гэхдээ Европын бүх улс, Засгийн газрууд нь төсвийн хэмнэлт гаргах шаардлагатай. Асуудал хурдан шийдэгдэнэ гэж хэлэхэд эрт байна. Ямар ч байсан хүнд байдлаасаа нашилсан.
- **Та сая Ираны асуудал хурцадвал газрын тосны үнэ нэмэгдэх эрсдэлтэй гэж ярилаа. Хэрвээ эвгүйдвэл хэчнээн хувиар нэмэгдэх эрсдэл байгаа бол?**
- Ираны Засгийн газартай холбоотой асуудал үүсэнгүүт л газрын тосны үнэ өсчихсөн. Асуудал улам хүндэрвэл үнэд ямар ч өөрчлөлт орж магадгүй. Бүр муудлаа гэхэд газрын тосны үнэ 50 орчим хувиар нэмэгдэх эрсдэл бий.

- **Ойрхи дорнодын асуудал намжвал газрын тосны үнэд ямар нэг өөрчлөлт орохоор байгаа юу?**
- Саяын дурдсан эрсдлийг тооцохгүй гэвэл газрын тосны үнэ 2012 онд өмнөх онтойгоо харьцуулахад 10 орчим хувиар өсч магадгүй гэсэн тооцоо бий. 2013 онд эргээд дөрөв орчим хувиар буурах тооцоо гарсан.

- **Газрын тосны үнэ эрс өсвөл металлын үнэд өөрчлөлт орж таарах байх даа?**
- Газрын тосны үнэ их хэмжээгээр өсвөл түүхий эдийн дэлхийн эдийн засгийн эрэлтэд нөлөөлнө. Эрэлт буурч, зэс гэх мэтийн металлын үнэд нөлөөлөх эрсдэлтэй.

- **Газрын тосны нийлүүлэлтэд тасалдал гаргах магадлал өндөр байгаа. Хэрвээ ийм байдал үүсвэл үнэд тэр хэрээр нөлөөлөх байх. Энэ талаар тодорхой тооцоо, судалгаа байдаг уу?**
- Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас/OECD/ Т гаргасан нэг судалгаа бий. Ирантай холбоотой асуудал хурцдаж, энэ байгууллагад багтдаг улсууд Иранаас газрын тос худалдаж авахаа больчихвол дэлхийн зах зээлийн нийлүүлэлтэд нөлөөлнө гэж үзсэн байсан. Хэрвээ ийм байдал үүсвэл газрын тосны үнэ 20-25 хувь өсч магадгүй гэсэн тооцоог OECD гаргасан.

- **Эдийн засгийн хямрал хурцдаад ирвэл зэс, нүүрсний үнэ ингэж унана гэсэн тодорхой тоо бий юу?**
- Бид судалгаагаа түүхий эд тус бүрээр нь хийдэггүй. Ерөнхийд нь багцлаад метал, эрчим хүч гээд явдаг учраас тодорхой хариулт өгөх боломжгүй л дээ. 2011 оны есдүгээр сард гарсан манай судалгааны тайланд Европын бүсийн нөхцөл байдал хурцадвал дэлхийн түүхий эдийн зах зээл дээр ямар үр дагавар авчрах талаар загварчлал бий. Тэр загварчлалаас харахад түүхий эдийн багцалсан үнэ 25 орчим хувиар унах эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан.

- **Хямралд бэлэн байхын тулд ямар бодлого хэрэгжүүлбэл зүгээр вэ?**
- Хамгийн гол нь хуримтлал үүсгэх ёстой. Зэсийн үнэ буурч эрсдэл үүссэн үед хуримтлалаа ашиглах хэрэгтэй. Зэсээс хамааралтай эдийн засгийн хувьд энэ металлын үнэ унавал бүх юм унадаг. Төсвийн орлого унаж, зээл буураад эхэлнэ. Зээл нь багасаад ирэхээр чанаргүй зээлийн багц нэмэгдчихдэг. Энэ мэтээр олон асуудал үүсдэг. Чили улс танай улстай адил зэсийн экспортоос хамааралтай. Чили зэсийн орлогоо тооцоолохдоо хараат бус экспертүүдийг ажиллуулдаг. Экспертүүд нь зэсийн үнэ урт хугацаанд хэд байх вэ гэсэн тооцооллыг гаргаж ирдэг. Тэр үнэдээ сууриалаад төсвийнхөө жил бүрийн орлогыг тооцдог. Орлогоос нь давсан хэсгийг хуримтлал болгож авч явдаг. Энэ их зөв арга.

- **Хуримтлалаас гадна ямар бодлого биднийг энэ эрсдлээс хамгаалах бол?**
- Мөнгөний бодлогоо хатуу байлгах хэрэгтэй. Бодлогын хүүгээ өндөр байлгах нь чухал. Дараа нь нөхцөл байдал эсрэгээр эргэвэл бодлогын хүүгээ бууруулж зээл

олгоход илүү таатай нөхцлийг бүрдүүлэх байдлаар төсвийн бодлогод дэмжлэг үзүүлж болох юм.

- **Түүхий эдийн уналт тодорхой хугацаанд үргэлжилдэг гэж та түрүүн онцолсон.**
- Ямар нэг үнэ доод цэгтээ хүрээд эргээд өсөхөд хэдий хэр хугацаа шаардах талаар судлахад 2,5-3 жил гэсэн тоо гардаг. Энэ хугацаанд үнэ 40-50 хувь болж буудаг гэсэн судалгаа бий. Түүхий эдийн сүүлийн арван жилийн үнийн хандлагыг ажиглахад ерөнхийдөө өссөн маягтай байгаа. Гэхдээ энэ арван жилийн дунд зарим үед нь үнэ огцом буурсан, огцом өссөн тохиолдол бий. Тэр үеийг нь л 2,5-3 жилээр үргэлжилдэг гээд байгаа юм. Үнэ ингэж өсч, буух үед эдийн засаг тодорхой цочролд орж, шинэ үнэдээ зохицон чиглэлээ өөрчилж явсаар өнөөдрийг хүрсэн гэсэн үг л дээ.
- **Сая та дэлхийн дэлхийн эдийн засгийн судалгааны талаар ярихдаа шинээр гарч байгаа эдийн засагтай улс гэж их ярилаа. Монгол улс энэ бүлэгт нь орж байгаа юу?**
- Бид өмнөх судалгаанууддаа улс орнуудыг хөгжингүй, шинэ тутам, хөгжиж байгаа гэж ангилж байсан. Харин энэ судалгаан дээр хөгжингүй ба бусад улс гэж ангилсан. Тэгэхээр Монгол бусад улс гэсэн ангилалд орсон гэсэн үг. Ингэж ангилсанахаа дараа улс орнуудыг түүхий эд тус бүрээр нь ялгасан. Монгол Улс зэс үйлдвэрлэгч болохоор металл үйлдвэрлэгч рүүгээ ороод явчихаж байгаа юм. Чилитэй адилхан гэсэн үг.
- **Та манай улсын эдийн хөгжлийн талаар ямар дүгнэлттэй явдаг вэ?**
- Би танай улсын талаар дагнаж судлаагүй болохоор тодорхой нарийн зүйл хэлэх боломжгүй байна. Гэхдээ Монгол бол байгалийн баялаг ихтэй орон. Тэр утгаараа их нөөц боломж харагдаж байгаа. Одоогоор эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ өндөр байна. Эрдэс баялгаас гол орлогоо олдог олон улсын эдийн засаг танай улс шиг хурдацтай өсч байгаа. Гэхдээ нөхцөл байдал муудах, бороо орох үед бэлтгэлтэй байх ёстой. Хамгийн гол нь хуримтлалаа сайн үүсгэж, эдийн засагтаа хэрэгтэй гэсэн хөрөнгө оруулалтдаа хийгээд явах ёстой.